

**БАТЛАВ**

**ТЭРГҮҮН ШАДАР САЙД  
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,  
ХӨГЖЛИЙН САЙД**

**БАТЛАВ**

**САНГИЙН САЙД**

**БАТЛАВ**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Н.УЧРАЛ**

**Б.ЖАВХЛАН**

**Л.МӨНХБААТАР**

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН  
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага**

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2-т “урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний гурван хувиар нэмэгдэх” гэж, мөн хуулийн 34.1.4-т “төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль, эрх зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасны дагуу Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Тус хуулиар Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, 20 минутын Үндэсний хорооны дарга нарыг Засгийн газрын бүрэлдэхүүнээс хассан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан зарим чиг үүрэг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжиж байгаа тул төсвийн зохицуулалт хийх шаардлага үүсээд байна.

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ 2025 оны эхний 5 сард дунджаар 72 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 39 хувиар, нийт экспорт 2025 оны эхний 5 сард 5.4 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 15 хувь

буюу 931 сая ам.доллароор, төсвийн нийт орлого 11.4 их наяд төгрөг болж, 11 хувь буюу 1.3 их наяд төгрөгөөр тус тус буурсан. Мөн эдийн засгийн өсөлт 2023 онд 7.4 хувь, 2024 онд 4.9 хувь байсан бол 2025 оны эхний улиралд 2.4 хувь болж буураад байна. Экспорт, төсвийн орлого буурч, эдийн засгийн өсөлт саарсны улмаас 2025 онд нэгдсэн төсвийн орлого тасрахаар байгаа нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагыг бий болгож байна.

Дээр дурдсан нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг боловсруулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үндсэн үзүүлэлтүүд болон үзүүлэлтийн хэмжээг өөрчлөх шаардлагатай байна.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөлд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг хүснэгтээр батлахтай холбогдсон зохицуулалтыг тусгана. Уг хуулийн төсөлд дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт, хэрэглээний үнийн индексийн түвшин, нэгдсэн төсвийн 2026-2027 оны тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ, нийт зарлагын дээд хэмжээ, тэнцвэржүүлсэн тэнцэл, суурь зарлагын хэмжээ, суурь тэнцэл, Засгийн газрын өрийн хэмжээ болон Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээний төсөөлөл шинэчлэгдсэнтэй холбогдуулан нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөлөлд энэ талаарх өөрчлөлтийг тусгана.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар Төсвийн хүрээний мэдэгдэл дэх макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг шинэчлэн тооцож, улсын төсвийг үр нөлөөтэй, оновчтой төлөвлөх, хуваарилах төсвийн бодлогыг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

### **Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулна.